



**Хууль тогтоомж зөрчигчдөд
хүлээлгэх хариуцлага,
өргөдөл, гомдол маргаан
хянан шийдвэрлэх харъяалал**

www.gec.gov.mn



Хариуцлагын төрөл

- Захиргааны хариуцлага
- Сахилгын шийтгэл
- Эрүүгийн хариуцлага
- Иргэний хууль болон бусад хуульд заасан хариуцлага

/Сонгуулийн тухай хуулийн 165 дугаар зүйл/



Хариуцлагын хэмжээ

- **Захиргааны хариуцлага**
 - нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-26 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох
- **Сахилгын шийтгэл**
 - Төрийн албан хаагчийг төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах



Хариуцлагын хэмжээ

- **Эрүүгийн хариуцлага**
 - үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол
- **Иргэний хууль болон бусад хуульд заасан хариуцлага**
 - бусдад эдийн болон эдийн бус хохирол учирсан бол



Хариуцлага

Төрийн албан хаагч нь:

1. Сонгуулийн хороодын хуралдаанаас гарсан шийдвэрт дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.
2. Сонгуулийн хороодын ажилтан, албан тушаалтныг үндсэн ажлаас нь **чөлөөлөх, огцруулах, өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.**
3. Төрийн байгууллага цалинтай чөлөө олгоно.

Зөрчсөн тохиолдолд төрийн албан хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.



Төрийн албан хаагч:

- сонгуульд оролцож байгаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах;
- сонгуульд оролцож байгаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн болон эсэргүүцсэн агуулга бүхий үйлдэл хийх, үйл ажиллагаа явуулах;
- сонгогчоос сонгуулийн эрхээ эдлэхэд нөлөөлөх, нөлөөлөхөөр оролдох;
- санал хураах, тоолох ажилд саад хийхийг **ХОРИГЛОНО.**

Зөрчсөн тохиолдолд төрийн албан хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.



Төрийн албан хаагч:

- бусдыг төлөөлж санал өгөх;
- зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмжийн лац, битүүмжлэлийг гэмтээх;
- гарын үсэг хуурамчаар үйлдэх;
- саналын хуудас солих;
- хүчингүй саналын хуудсаар санал авах;
- хуулиар хориглосон бусад аливаа үйлдэл гаргах, зохион байгуулах, оролцохыг **ХОРИГЛОНО.**

Зөрчсөн тохиолдолд төрийн албан хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.



Хариуцлага

Сонгууль зохион байгуулах талаар эрх хэмжээнийхээ дотор гаргасан аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрийг холбогдох этгээд биелүүлэх үүрэгтэй.

Зөрчсөн тохиолдолд төрийн албан хаагчийг төрийн албанаас хална.



Өргөдөл, гомдол, маргаан шийдвэрлэх харьяалал

- Сонгуулийн зохион байгуулалттай холбоотой **өргөдөл**
 - Сонгуулийн байгууллагад гаргана.
- Сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэртэй холбоотой **НЭХЭМЖЛЭЛ**
 - Захиргааны хэргийн шүүхэд анхан шатны журмаар
- Сонгуулийн Ерөнхий Хорооны шийдвэртэй холбоотой **НЭХЭМЖЛЭЛ**
 - Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар
- **Зөрчил**
 - Цагдаагийн байгууллага шалгаж, шүүхээр шийдвэрлүүлнэ.



Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны нийтлэг эрх хэмжээ

- 1.сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;
- 2.сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, сахин биелүүлэх явдлыг хангах;
- 3.харьяалах доод шатны сонгуулийн байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;
- 4.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, албан бичигт эрх хэмжээнийхээ хүрээнд хариу өгөх, шийдвэрлэх;



Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны нийтлэг эрх хэмжээ

5.сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар тухайн нутаг дэвсгэрийн зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

6.хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

7.санал авах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, бусад зүйлийг харьяалах сонгуулийн хороодод хуваарилах;



Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны нийтлэг эрх хэмжээ

8.холбогдох баримт материалыг хэвлүүлэх,
хуваарилах;

9.өөрийн нутаг дэвсгэрт явагдсан сонгуулийн дүнг
нэгтгэж, сонгуулийн төв байгууллагад хүргэх;

10.сонгуулийн баримт бичгийг зохих журмын дагуу
цэгцэлж, холбогдох этгээдэд хүлээлгэн өгөх;

11.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан дээд
шатны сонгуулийн байгууллагаас өгсөн үүрэг,
даалгаврыг биелүүлэх;



Санал авах байрны эрх, үүрэг

1. санал авах байрны хаяг, санал авах өдөр, цагийн хуваарийг сонгогчдод мэдээлэх;
2. сонгогчийг шилжүүлэх, шилжиж ирсэн сонгогчийг бүртгэх тухай асуудлаар улсын бүртгэлийн холбогдох байгууллага, албан тушаалтантай харилцах;
3. санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, сонгогчийн бүртгэлийн болон санал тоолох төхөөрөмж зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэх;



Санал авах байрны эрх, үүрэг

4.сонгогчдын санал авах, тоолох ажлыг зохион байгуулах;

5.санал хураалтын дүн, холбогдох бичиг баримтыг сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргэх;

6.сонгуулийн баримт бичгийг зохих журмын дагуу цэгцэлж, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;

6.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, албан тоотыг эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэрлэх;



Өргөдөл гомдол гаргах

Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахтай холбоотой гаргасан шийдвэр нь **ТОГТООЛ, ЗӨВЛӨМЖ, албан бичгийн хэлбэртэй** байна.



Цаг хугацаа, орон зайнаас хамаарч өргөдлийг факсаар гаргаж болно.



Өргөдөлд дараах мэдээллийг тусгана

1. өргөдөл гаргасан хүний нэр, эцгийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар /хоёр ба түүнээс дээш хүн гаргасан бол хүн тус бүрээр/;
2. өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
3. шуудангийн хаяг;
4. холбоо барих хоёроос доошгүй утасны дугаар /өөрийн болон зайлшгүй шаардлагатай үед дамжуулан холбоо барьж болох этгээдийн/;
5. цахим шуудангийн хаягтай бол цахим шуудангийн хаяг;
6. төлөөлөгч томилсон бол төлөөлөгчийн нэр, эцгийн нэр, төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар;
7. өргөдөл гаргах үндэслэл, түүний нотолгоо, баримт, түүнчлэн ямар асуудал шийдвэрлүүлэхийг хүсч байгаа талаар.



Өргөдөл шийдвэрлэх

Сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан өргөдлийг хүлээн авсан зохих шатны сонгуулийн байгууллага өөрийн эрх хэмжээний асуудал мөн бол **гурав хоногийн дотор** шийдвэрлэнэ

хуулиар эрх хэмжээ олгоогүй асуудлаар ирүүлсэн өргөдлийг тухайн сонгуулийн байгууллага хүлээн авахаас татгалзаж, өргөдлийг буцаана.

→ шийдвэрийг эс зөвшөөрвөл өргөдөл гаргагч дээд шатны сонгуулийн байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.



www.gec.gov.mn